

## **School Talk Email/News Release Сургуулийн харилцах имэйл/мэдээ нийтлэл**

**Title:** Instructional Delivery Model & Transportation Selection Process for Middle & High School Students

**Гарчиг:** Дунд болон ахлах ангийн сурагчдад хүргэх сургалтыг хүртээмжийн хэлбэр, тээврийн хэрэгслийг сонгох үйл явц

**Буцах 3-р түвшний сургалтын хүртээмжийн арга хэлбэр болон тээвэрлэлтийг сонгох үйл явцын гол үе шатууд**

1. Буцах 3-р шатны шалгаруулалт нь 6-12-р ангийн сурагчдад зориулагдсан болно.
2. Сонгон шалгаруулалтын хугацаа нь 11-р сарын 30-ны Даваа гарагаас 12-р сарын 7-ны Даваа гараг хүртэл байна.
3. Эцэг эхчүүд холимог/биеэр эсвэл бүтэн цагаар зайнаас сонгон суралцах боломжтой.
4. Сургуулийн автобусаар нэг удаадаа зөвхөн 11 сурагч явах боломжтой бөгөөд бүх сурагчид сургуулийн автобусанд суухаасаа өмнө эрүүл мэндийн үзлэгт хамрагдах болно.
5. Бүх эцэг эхчүүд сонголт хийх ёстой бөгөөд сургалтын хүртээмжийн анхны загвар байхгүй байна.
6. Сургуулиуд нь бүх эцэг эхчүүдийг сонгон шалгаруулалтын цонх хаагдахаас өмнө сонголт хийхийг сурталчлах ажлыг зохион байгуулна.

Буцах 2-р түвшний сонгон шалгаруулалтын үйл явцын талаархи нэмэлт мэдээлэл [\[LINK\]](#) [\[ХОЛБООС\]](#)

---

Дунд, ахлах ангийн сурагчдыг хамарсан 3-р түвшний буцах сурагчдын сонгон шалгаруулалт өнөөдөр буюу 11-р сарын 30-ны өдөр нээгдэж, 12-р сарын 7-ны Даваа гаригт хаагдана. 3-р түвшний сурагчидыг 1-р сард хичээлд нь эргэж оруулах нь аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэх зорилготой. Дунд сургуулийн бүх эцэг эхчүүд сонгон шалгаруулалтанд хариу үзүүлж сонголт хийхийг уриалж байна.

Хэдийгээр эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал зөвхөн зайны сургалтанд хамрагдахыг зөвшөөрч байгаа ч гэсэн АНС нь сурагчдыг сургуульдаа буцаж ирэхэд аюулгүй байх боломжит хугацааг төлөвлөхийн тулд эцэг эхчүүдийг сургалтын хүртээмж, тээвэрлэлтийн сонголтыг хийхийг хүсч байна. Сонгон шалгаруулалтыг хойшлуулж, аюулгүй гэж үзсэн тохиолдолд ч сургууль нээхгүй байна гэсэн үг биш юм.

### **Сургалтын хүртээмжийн хэлбэр**

Сургууль эргэн нээгдэхэд эцэг эхчүүд хүүхдээ биечлэн болон холимог хэлбэрээр суралцхаар сургуульдаа ирэх үү, эсвэл бүтэн цагийн зайн сургалтаар үргэлжлүүлэн хичээллэх үү гэдгийг нь шийдэж болно. Бүх эцэг эхчүүд сонгон шалгаруулалтанд оролцох шаардлагатай, учир нь сургалтын хүртээмжийн арга хэлбэр байхгүй тул сургуулиуд эцэг эхчүүдээр сонголт хийлгэх болно. Эцэг эхчүүд бүтэн цагийн зайн сургалт эсвэл холимог/биеэр суралцах хэлбэрийн алийг сонгосон эсэхээс үл хамааран сурагчид хичээл заах багш өөрчлөгдөхгүй.

Анги түвшин тус бүр сургалтын хүртээмжийн аргын дараахь хоёр сонголттой байна:

- **Бүтэн цагийн зайн сургалт** - Бүтэн цагийн зайн сургалтанд хамрагдах сурагчид интерактив, багшийн удирдлаган дор (синхрон) болон асинхрон сургалтын аль алиныг нь одоогийн байгаа шигээ үргэлжлүүлэн авах болно.
- **Дунд сургуулийн холимог загвар** - Дунд сургуулийн сурагчид долоо хоногийн дөрвөн өдөрт буюу Мягмар-Баасан гарагт синхрон зааварчилгаа авна. Холимог загварыг сонгосон сурагчид долоо хоногт хоёр өдөр өөрийн биеэр сургуульдаа суралцах болно. Багш нар холимог сургалтын загварыг ашиглан хоёр бүлгийн сурагчидад зааварчилгаа өгнө. Энэ нь сургуулийн зарим сурагчид багшаас зайнаас заавар авах болно гэсэн үг юм; эдгээр сурагчидад ангийн туслахууд биечлэн хяналт тавьж, туслах болно. Эцэг эх, ажилчдын дунд явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд зөвхөн цахимаар сурдаг сурагчид оролцдог зарим нэг хичээл байж болох бөгөөд ийм тохиолдолд цагийн хуваарьт өөрчлөлт орж болох юм.
- **Ахлах сургуулийн холимог загвар** - Ахлах ангийн сурагчид долоо хоногийн дөрвөн өдөрт буюу Мягмар-Баасан гарагт синхрон зааварчилгаа авна. Холимог загварыг сонгосон сурагчид долоо хоногт хоёр өдөр өөрийн биеэр сургуульдаа суралцах болно. Багш нар холимог сургалтын загварыг ашиглан хоёр бүлгийн сурагчидад зааварчилгаа өгнө. Энэ нь сургуулийн зарим сурагчид багшаас зайнаас заавар авах болно гэсэн үг юм; эдгээр сурагчидад ангийн туслахууд биечлэн хяналт тавьж, туслах болно.

Холимог/Биечлэн суралцах сонголтыг хийх гэж буй эцэг эхчүүдэд [“Ерөнхий боловсролын сургуулийн холимог/биечлэн суралцах өдөр”](#) инфографик, [“Дунд сургуулийн холимог өдөр”](#) видео бичлэгийг мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын холимог/биечлэн суралцах тоймыг үзэхийг зөвлөж байна. Сургалтын хүртээмжийн арга хэлбэр, сургуулийн хуваарийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг [2020-21 оны хичээлийн жил](#)-ийн вэбсайтаас авах боломжтой.

### **Сургалтын хүртээмжийн загварын өөрчлөлт**

Анги танхимд барих зай, ажилчдын орон тоо, цагийн хуваарь дүүргэлт зэрэг хязгаарлалтын улмаас эцэг эхчүүд 3-р түвшний сурагчидын хичээл эхлэхээс нааш хүүхэддээ сонгосон сургалтын хүртээмжийн загвараа өөрчлөх боломжгүй болно. Үүний дараа өөрчлөлт оруулах хүсэлтээ сургуулийн захиралд гаргах ёстой бөгөөд орон тоо, хүчин чадлын хязгаарлалтыг харгалзан үзэж өөрчлөлтийг тухайн тохиолдолд зөвшөөрч болно.

### **Тээвэрлэлтийн тухай чухал мэдээлэл ба өөрчлөлт**

АНС нь эцэг эхчүүдийг сургуульдаа буцаж орох ажлын нэг хэсэг болох сургалтын хүртээмжийн загвараас сонгохоос гадна тээврийн хэрэгсэл сонгохыг хүсч байна. Бүтэн цагийн зайн сургалтын загварыг сонгох тохиолдолд тээвэрлэлтийн мэдээллийг бөглөх шаардлагагүй болно. Хичээлийн холимог, биечлэн суух загварыг сонгож буй эцэг эхийн хувьд сурагчид нь автобусанд суух эсэхийг сонгох ёстой. Хэрэв биечлэн суралцах цаг үе эхэлхэд автобусаар явахгүй бол ашиглах тээврийн хэрэгслийн төрлийг сонгоно уу.

Эцэг эхэд тээвэрлэлтийн тухай чухал ач холбогдолтой мэдээлэл:

- Автобусанд зорчигчийн мэдээллийг (зогсоол, цаг) ParentVUE-д бүртгэх болно. Маршрут гаргахад цаг хугацаа хомс байшаа тул, автобусны стандарт захидал илгээхгүй. Эцэг эхчүүд хүүхдийнхээ сургууль руу залгаж автобусны зогсоол, цагийг нь асууж болно. Сурагчид авсан цагийн хуваариа дагаж мөрдөх ёстой.

- Автобус бүрт дээд тал нь 11 сурагч зорчих болно. Нэг удаад 11 зорчигч тээвэрлэхийн тулд автобуснууд сургууль руу олон удаа нааш цааш явах шаардлагатай болно. 11-ээс дээш сурагч хуваарилагдсан зогсоолын хувьд зогсоол бүрт хэд хэдэн удаа очиж ирдэг. Сургчидад хуваарийн дагуу суух цаг олгоно. Эцэг эхчүүд товлосон цагаасаа 10 минутын өмнө автобусны буудал дээр байхаар төлөвлөх нь зүйтэй ба, автобус хараахан ирээгүй бол дор хаяж 10 минут хүлээх хэрэгтэй.
- Автобусанд хуваарилагдаагүй сурагчид автобусанд суухгүй байж болно. Автобусны үйлчлэгчид эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, сурагчын явах хуваарилалтыг шалгаж жагсаалтыг гаргана.
- Зорчигчдыг өглөө болон үдээс хойш автобусаар явахыг уриалж байна. Автобус ашигладаггүй сурагчидын суудалыг дахин хуваарилна.
- Автобусны үйлчлэгчид зогсоол бүрт сурагчидыг шалгана. Хэрэв сурагч халуурах эсвэл бусад шинж тэмдэг илэрвэл автобусанд суухгүй тул гэртээ харих ёстой. Ийм тохиолдолд эцэг эхчүүд нөөц төлөвлөгөөтэй байх ёстой.
- Сурагчид автобусанд суухдаа заавал маск зүүсэн байх ёстой.
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамжийн дагуу суудал тус бүрт зөвхөн нэг сурагч суухыг зөвшөөрнө. Сурагчидын хэрэглээнд зориулж суудлыг тэмдэглэнэ.
- Тусгай хэрэгцээний автобусанд ах дүүс хамт явахыг хориглоно.

Ихэвчлэн их ачаатай явдаг зорчигчдтой автобусны чиглэлүүдэд автобус сургууль руу хэд хэдэн удаа нааш цааш явах шаардлагатай болдог. Энэхүү өөрчлөлт нь АНС нь автобусны зорчигчдыг хаанаас, хэрхэн яаж авах талаар зарим өөрчлөлтийг хийж, тээврийн алба автобусны үйлчилгээг сургуулиас хамгийн хол чиглэлд төвлөрүүлж, зогсоол, сургуулийн хооронд илүү хурдан шилжих боломжийг олгох ёстой. Заавал шаардагдаагүй хичээл, хөтөлбөрт хамрагдаж буй сурагчидыг төв цэгүүдэд хуваарилна. Эцэг эхчүүд ParentVUE дээрх бичиг баримтын хавтас дээрх зогсоолын мэдээллийг хянаж үзэх шаардлагатай.

### **ParentVUE дээр хэрхэн сонгох хийх болон сонголтоо өөрчлөх вэ**

Сургалтын хүртээмжийн хэлбэр, тээврийн асуултанд сонголтоо хийхийн тулд эцэг эхчүүд ParentVUE дээр дараахь алхамуудыг хийх шаардлагатай болно:

1. Хэрэглэгчийн нэр, нүүц үгээрээ ParentVUE руу нэвтрэх.
2. Нэвтрэнгүүт эхний цонхонд "Сурагчын мэдээлэл" хуудас харагдах болно.
3. "Сурагчын мэдээлэл" хуудасны дээд хэсэгт "Мэдээлэл засах" дээр дарж сургалтын хүртээмжийн арга, тээвэрлэлтийн асуултанд хариулж сонголтоо хийнэ үү.
4. Сургалтын хүртээмжийн арга, тээвэрлэлтийн асуултанд сонголт хийхийн тулд "Оюутны мэдээлэл" хуудасны дундуур гүйлгэнэ үү.
5. Хариултаа сонгосны дараа хуудасны дээд эсвэл доод хэсэгрүү гүйлгэж "Өөрчлөлтийг хадгалах" -ыг дарна уу.
6. Хэрэв та нэгээс олон сурагчтай бол ParentVUE дээр дэлгэцийн зүүн дээд буланд байрлах нүдэнд нэрийг нь сонгон сурагч тус бүрт энэ үйлдлийг давтан хийх шаардлагатай болно.

**Эцэг эхчүүд сурагчиддаа сургалтын хүртээмж, тээврийн хэрэгслийг сонгоход бэлэн болсны ParentVUE-д хандахын тулд дараах холбоосыг ашиглаж болно: <https://vue.apsva.us>.**

ParentVUE-тэй холбоотой нэмэлт мэдээлэл, туслалцаа авахын тулд эцэг эхчүүд хүүхдийнхээ сургуультай холбоо барих эсвэл эцэг эхийн технологийн дуудлагын төвийн 703-228-2570 дугаар луу залгана.

**Text Message Бичвэр зурвас**

Дунд болон ахлах ангийн сурагчдын эцэг эхчүүд одоо сургалтын хүрээмжийн хэлбэр, тээвэрлэлтийн сонголтоо ParentVUE дээр шинэчлэх боломжтой байгаа. [\[LINK\]](#) [\[ХОЛБООС\]](#)